

ӨГҮҮЛЭЛ

Төв Азид чиглэсэн АНУ-ын бодлого**Лугуушаравын Бямбаханд**

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
byambakhand_1@mas.ac.mn

Хураангуй: Есдүгээр сарын 11-ний террорист халдлагын дараа АНУ цэргийн ажиллагаа явуулж, Афганистанд цэргээ байрлуулсан Талибуудтай байгуулсан “Афганистанд энхийн гэрээний”-ний үр дүнд 2021 оны наймдугаар сард АНУ Афганистанаас сүүлчийн цэргээ гаргаж, 20 орчим жилийн дараа цэргээ гаргасан юм. Төв Азийг судалдаг шинжээчдийн үзэж байгаагаар, АНУ нь цэргээ Афганистанаас гаргаснаар тус улстай ойр орших Төв Азийн бүс нутгийн талаарх АНУ-ын бодлогод тодорхой өөрчлөлт гарах төлөвтэй байна. Гэсэн хэдий ч Оросын Украинд явуулж буй дайн байлдааны үйл ажиллагаанаас үүдэн АНУ Европын аюулгүй байдлыг анхаарахаас өөр аргагүй байдалд ороод байгаа юм. Үүнээс болоод Төв Азид Орос, Хятад нь давамгайлах нөлөөгөө хадгалах боломжтой. Зохиогч өгүүллийн эхний хэсэгт Төв Азийн геополитикийн ач холбогдол, бүс нутагт нөлөөгөө тэлэхийн төлөөх их гүрнүүдийн өрсөлдөөнд дүн шинжилгээ хийлээ. Түүнчлэн АНУ-ын Үндсэн хуульд зааснаар тус улсын ерөнхийлөгч гүйцэтгэх засаглалын тэргүүний хувьд улс орныхоо гадаад бодлогыг тодорхойлоход чухал үүрэгтэй тул өгүүллийн хоёрдугаар хэсэгт АНУ-ын үе үеийн ерөнхийлөгчийн Төв Азийн талаар баримталж буй бодлогыг авч үзсэн. Өгүүллийн төгсгөлд АНУ-ын цэргийг Афганистанаас гаргах тухай Ерөнхийлөгч Ж.Байдены шийдвэртэй холбогдуулан Вашингтоны Төв Азийн талаарх бодлогод гарч болзошгүй өөрчлөлтийн талаар судлаачийн байр сууриа хуваалцсан юм.

Түлхүүр үгс: Төв Ази, АНУ-ын бодлого, Афганистан, геополитик, ашиг сонирхол



Оршил

“Есдүгээр сарын 11-ний алан хядах ажиллагаа”-тай холбогдуулан Афганистанд цэрэг-дайны үйл ажиллагаа явуулж, 2001 оноос хойш цэргээ байрлуулсан. Ерөнхийлөгч Б.Обамагийн засаг захиргаанаас эхлэн Вашингтон Афганистанаас цэргээ бүрэн гаргах тухай ярьж эхэлсэн. 2020 оны 2 дугаар сард АНУ болон Талибан хөдөлгөөний хооронд энхийн гэрээ байгуулж, Афганистанаас АНУ-ын цэргийг гаргаж, Афганистаны дотоод яриа хэлэлцээг эхлүүлсэн. Энэ нь сүүлийн 18 жилийн хугацаанд болсон анхны энхийн хэлэлцээр байв. Энэхүү энхийн хэлэлцээрийн дараа АНУ нь 2021 оны 5 дугаар сарын 1-нээс Афганистанаас цэргээ албан ёсоор гаргаж эхэлсэн. Афганистанд АНУ болон НАТО-гийн цэргийн оролцоо 2021 оны 9 дүгээр сарын 11-нээс бүрэн дуусгавар болно гэдгийг мэдэгдсэн билээ.

АНУ Афганистанаас цэргээ татсан нь тус улстай ойр оршдог Төв Азийн орнуудын хувьд томоохон өөрчлөлтийг авчирна гэх хүлээлт тус бүс нутгийг ажиллан судалдаг судлаачдын дунд үүсээд байсан юм. Гэвч 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч Украинд орос гаралтай иргэдийн эсрэг неонацист үзэл идэвхжиж, цэрэг-зэвсгээр хөөцөлдөх явдал гаарч буйтай холбогдуулан “цэргийн тусгай ажиллагаа” явуулах болсноо зарласан билээ.¹ ОХУ-ын өдүүлсэн цэрэг-дайны үйл ажиллагаатай холбогдуулан

Вашингтоны зүгээс Транс-Атлантын аюулгүй байдалд анхаарлаа хандуулахаас өөр аргагүй байдалд хүрсэн нь Төв Ази дахь АНУ-ын бодлогыг зогсонги байдалд оруулаад байна.

Толилуулан буй өгүүллийн эхний хэсэгт Төв Азийн геополитикийн ач холбогдол хийгээд тус бүс нутагт нөлөөгөө тогтоохын төлөөх их гүрнүүдийн өрсөлдөөнд дүн шинжилгээ хийх юм. АНУ-ын Үндсэн хуульд заасанчлан, гүйцэтгэх засаглалын тэргүүний хувиар Ерөнхийлөгч нь тус улсын гадаад бодлогыг тодорхойлоход үлэмж нөлөөтэй учраас өгүүллийн хоёрдугаар хэсэгт Төв Азид АНУ-ын явуулж ирсэн бодлогыг үе үеийн ерөнхийлөгчдийн бодлого, үйл ажиллагаатай холбогдуулан авч үзнэ. Төгсгөлд нь Ерөнхийлөгч Ж.Байден АНУ-ын цэргийг Афганистанаас гаргахаар шийдвэрлэсэнтэй холбоотойгоор Төв Азид Вашингтоны явуулж бодлогод ямар өөрчлөлт гарч болзошгүй талаар судлаачийн байр сууриа илэрхийлэх юм.

Хүйтэн дайны төгсгөлд ЗХУ задран унаснаар дэлхийн II дайны дараа үүссэн олон улсын харилцааны хоёр туйлт систем төгсгөл болж, дэлхийн шинэ дэг журам бүрэлдэх үйл явц эхэлсэн. Тэр үеэс өнөөг хүртэлх хугацаанд олон улсын харилцаанд “нэг туйлт систем” бий болоод байгаа хэмээн судлаачид дүгнэдэг. Олон улсын харилцаанд манлайлагч их гүрэн болох

1 TASS “Decision taken on denazification, demilitarization of Ukraine — Putin” (February 24, 2022) https://tass.com/politics/1409189?utm_source=google.com&utm_medium=organic&utm_campaign=google.com&utm_referrer=google.com (accessed September 10, 2022)

АНУ болон бусад гүрний хоорондын ялгаа их байснаас 1990-ээд оны сүүл үеийн олон улсын харилцааг үндсэндээ “нэг туйлт” хэмээн тодорхойлдог.

“Есдүгээр сарын 11-ний хэрэг явдал” цэргийн хүч чадлаа Афганистанд бүрэн дүүрэн үзүүлэх боломжийг Америкт олгов. Өмнө нь геополитикч Н.Спайкманы “римланд” (rimland) хэмээн нэрлэсэн Евразийн эргийн бүс нутагт Америкийн цэрэг арми нэвтрэн орж дайн хийдэг байсан (тухайлбал, Солонгосын дайн, Вьетнамын дайн) бол энэ удаа “тэнгисийн их гүрэн” гэгдэх АНУ нь Х.Маккиндерийн тодорхойлсон “зүрхэн газар” (heartland)-г нэвтэрч чадсан юм.

Афганистаны дайн нь АНУ-тай эвсэж холбоолох улсуудын түншлэлийг эрчимжүүлсэн. Өөр хоорондын асуудалдаа анхаараад байсан Энэтхэг, Пакистан улсын бодлого Америкийн зүг эргэв. Афганистаны дайнд Пакистан АНУ-д ложистикийн дэмжлэг үзүүлэв. Энэтхэг агаарын хилээ АНУ-д ашиглуулан, Афганистаны дайнд туслалцаа үзүүлснээр хоёр улсын харилцаа урьд өмнө байгаагүй өндөр түвшинд хүрсэн. ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин 9/11-ний хэрэг явдлыг “исламын хэт даврах үзэл”-тэй тэмцэх далим хэмээн үзэхийн сацуу Өрнөдийн орнуудад хүлээн зөвшөөрөгдөх боломж хэмээн харснаар ОХУ нь тодорхой хэмжээнд АНУ-тай хамтран ажилласан. Харин Хятадын хувьд энэ асуудлаас хол хөндий байсан боловч АНУ-ын исламын хэт даврах үзлийн эсрэг тэмцэл нь Бээжингийн ашиг сонирхолтой нийцэж байсан учраас терроризмын эсрэг дайнд хамтран ажиллахын зэрэгцээ Номхон далайд АНУ-тай чимээгүй өрсөлдөж

эхэлсэн.

Олон улсын харилцаан дахь АНУ-ын давамгайлал Орос, Хятадыг ойртон нягтрахаас өөр аргагүй байдалд хүргэв. АНУ-ын давамгайлсан “нэг туйлт” тогтолцоо нь хоёр талын аль алиных нь ашиг сонирхолд нийцэхгүй байсан юм. Тиймээс Москва, Бээжин хоёр стратегийн түншлэл 1996 онд тогтоож, АНУ болон Өрнөдийн нөлөөг хязгаарлах, Хятад, Орос илүү нөлөөтэй байх “олон туйлт” тогтолцоог бий болгохыг зорьж байна.

Харин ирээдүйд Бээжин, Москвагийн зам Төв Азиас болж салж болзошгүй байна. Төв Ази бол үнэн хэрэгтээ Х.Маккиндерын Евразийн умард төв хэсэгт дэлхийн бодлогын “зүрхэн газар” хэмээн тодорхойлсон тэрхүү бүс нутаг юм. Х.Маккиндер энэ бүс нутагтай хамгийн ойр газрууд болох Герман, Австри, Турк, Энэтхэг, Хятадыг “дотоод хавирган сар” (inner crescent) гэх бүс нутагт хамруулсан бол Их Британи, Өмнөд Африк, Австрали, АНУ, Канад, Японыг “гадаад хавирган сар” (outer crescent) хэмээн тодорхойлсон. Евразийн төвд орших аль нэг улсад давуу тал үүсгэн хүчний тэнцвэр эвдэгдэх нь Евразийн захын бүс нутаг руу тэлэх боломжийг олгож, эх газрын нөөцийг усан флот байгуулахад ашиглах замаар дэлхийн эзэнт гүрнийг байгуулж чадна гэж Х.Маккиндер үзэж байв.

“Зүрхэн газар”-г нөлөөгөө тогтоохын тулд Хятад Төв Ази руу санаархаж эхэлсэн. Энэ санаархал нь тус улсын 2013 оноос хойш хэрэгжүүлж буй “Бүс ба зам” санаачилгаар илэрч байна. “Бүс ба зам” санаачилгаар дамжуулан Бээжин Төв Азиас бусад их гүрэн, ялангуяа Оросыг шахаж гаргах замаар өөрийн

нөлөөндөө оруулахыг зорьж байна. Крымын хямралтай холбоотойгоор ОХУ-д Өрнөдийн орнуудын тавьсан хоригийн улмаас Төв Азид Москвагийн эдийн засгийн нөлөө буурч, бүс нутгийн орнуудад зориулах хөрөнгө оруулалтын хэмжээ буурч байхад, эсрэгээрээ, Хятадын эдийн засгийн болон улс төрийн нөлөө өдрөөс өдөрт нэмэгдэж байна. Олон тооны тэтгэлэг олгох, Төв Азийг судалдаг 20 гаруй төвийг байгуулах зэргээр БНХАУ нь Төв Ази руу чиглэсэн зөөлөн хүчний бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж байна.²

Эртнээс Төв Ази нь Оросын нөлөөний бүсэд хамаарсаар ирсэн. Москва энэ бүс нутгийн орнуудыг “ойрын хилийн чанад” (ближнее зарубежье) хэмээн тодорхойлдог. ОХУ нь бусад улс тус бүс нутагт нөлөөгөө тогтоохын эсрэг байдаг. Москвагаас өөр улсууд Төв Азид нөлөөтэй болох нь эргээд Оросын нөлөөг хязгаарлана хэмээн “тэг дүнтэй тоглоом” (zero-sum game)-ын үүднээс оросын стратегичид үздэг. Хятадтай харьцуулахад Орос нь эдийн засгийн хүчин чадал сул учраас Төв Азийн орнуудтай Хамтын аюулгүй байдлын гэрээний байгууллага, ШХАБ-аар дамжуулан цэрэг-батлан хамгаалахын салбарт хамтран ажиллаж, нөлөөгөө хадгалахыг эрмэлздэг. Мөн Төв Ази дахь Хятадын эдийн засгийн нөлөөг хязгаарлах зорилгоор ОХУ нь Беларусь, Казахстан, Армен, Кыргызстаныг эгнээндээ нэгтгэсэн Евразийн эдийн засгийн холбоо (ЕАЭЗХ)-г байгуулан, эдийн засгийн нөлөөгөө эргүүлэн авахыг оролдож байна.

Өнөөгийн байдлаар АНУ-ын давамгайлалыг сөрөн зогсоход ОХУ-ын “дэмжлэг” чухал учраас Төв Азид Оростой илт сөргөлдөх нь Хятадад

ашиггүй юм. Тиймээс Бээжин цэрэг-батлан хамгаалахын салбарт Москвагай өрсөлдөхгүй байх, эрчим хүч, хөрөнгө оруулалт, зээл болон ШХАБ-ын хүрээнд хэт даврах үзэл, терроризмын салбараар Төв Азийн орнуудтай тогтоосон хамтын ажиллагаагаа хязгаарлах бодлого баримталж байна. ОХУ-ын эдийн засгийн ашиг сонирхолтой шууд мөргөлдөхгүйн тулд “Бүс ба зам” санаачилгыг ЕАЭЗХ-той уялдуулахыг эрмэлздэг. Гэвч Бээжин хэдий хүртэл Оросын “аяыг харсаар байх” нь тодорхойгүй юм. Хэрэв “Бүс ба зам” санаачилга амжилттай хэрэгжин, хөрөнгө оруулалт нь Төв Азид нэмэгдвэл, шаардлагатай тохиолдолд гадаадад байгаа хөрөнгө оруулалтаа “цэргийн хүч”-ээр хамгаалах номлолтой Хятад бүс нутгийн орнуудтай цэрэг, аюулгүй байдлын салбарт нягт харилцахаас өөр аргагүй билээ.

Хоёр. Төв Азид чиглэсэн АНУ-ын бодлого

Төв Ази нь баруун талаараа Каспийн тэнгис, хойд талаараа Орос, зүүн талаараа Хятад, өмнө талаараа Афганистан, Ирантай хиллэдэг далайд гарцгүй бүс нутаг юм. Тийм учраас энэ бүс нутагт идэвхтэй бодлого явуулах нь “далайн их гүрэн” болох АНУ-д геополитикийн тухайд нэлээд хүндрэлтэй даалгавар юм. ЗХУ-ын задралын үр дүнд тусгаар тогтносон Төв Азийн таван улсын бие даасан, бүрэн эрхт байдлыг хамгийн түрүүнд хүлээн зөвшөөрсөн орнуудын дунд АНУ багтана. Вашингтоны зүгээс эдгээр улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг дэмжих бодлогыг өнөөг хүртэл баримталсаар ирсэн нь Оросыг дахин Евразийн “зүрхэн газар”-т их гүрэн болохоос сэргийлэхэд чиглэж байгаа нь нууц биш юм.

Төв Азийн улсууд 1991 онд тусгаар тогтносны дараа АНУ нь тус бүс нутагт эрчимтэй бодлого хэрэгжүүлээгүй байна. Төв Ази нь ЗХУ-ын ашиг сонирхлын бүсэд хамаарч ирсэн учраас Вашингтоны тухайд төдийлөн танил бус бүс нутаг байсан нь үүний шалтгаан болдог. Энэ үед Төв Ази нь АНУ-д хоёрдугаар зэргийн ач холбогдолтой бүс нутаг байсан юм. Тус бүс нутгаас илүүтэй Европ, Ойрх Дорнодод анхаарч байв. Үүний улмаас АНУ энэ бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад оролцох сонирхолгүй байсан бөгөөд энэ нь 1995 оны Тажикистаны иргэний дайнд оролцохоос татгалзснаас харагддаг. Нөгөөтэйгүүр, ОХУ Төв Азид нөлөөгөө эргэн бэхжүүлэхэд Вашингтоны зүгээс

хориг саад тавиагүй нь хүйтэн дайны дараах АНУ-Оросын харилцааны “бал сар”-тай холбоотой.³

ОХУ нь “ойрын хилийн чанад” номлолынхоо бүрээнд бүс нутагт нөлөөгөө нэмэгдүүлж байсан бол Иран, Хятад зэрэг бусад улсын нөлөө ч өсч, 1990-ээд оны сүүлийн хагаст исламын хэт даврах үзэлтнүүд идэвхжих болсноор АНУ нь бүс нутаг дахь гадны хүчний оролцоог сөрж тэнцвэржүүлэх, “тусгаарлагч”-ийн үүрэг гүйцэтгэх хэрэгтэй болсон. Үүний үр дүнд, Ерөнхийлөгч Б.Клинтаны засаг захиргаа бүс нутагт гаднын оролцогчдын оролцоог тогтоон барих бодлого хэрэгжүүлсэн. Энэ үед АНУ-ын Төв Азид хэрэгжүүлсэн бодлого нь Зөвлөлтийн үеийн үй олноор хөнөөх зэвсгийн нөөцийг аюулгүй болгох, Оросын “нео-империалист” бодлогоос Төв Азийн шинээр тусгаар тогтносон улсуудын бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, Төв Азийн байгалийн хийн болон транзит тээврийн замуудад Оросын монополь тогтоохоос хамгаалахад чиглэж байв.

Зөвлөлтийн үеийн үй олноор хөнөөх зэвсгийн нөөцийг аюулгүй болгох чиглэлд анхаарч, 1991 оны 12 дугаар сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Ж.Бейкер Казахстанд айлчилж, тус улсыг цөмийн зэвсэгтэй улсын статусаас татгалзахыг ятгасан. Казахстанд байсан зэвсэг техникийг Орос руу зөөхөд анхаарч, Казахстантай “Хамтран аюулыг бууруулах” гэрээнд 1993 онд гарын үсэг зурсан.⁴ АНУ-

3 Troitskiy, E, F. US policy in central Asia and regional security.

4 Alam M. M. US Policy In Central Asia: Problems And Prospects.

ын Дэд ерөнхийлөгч А.Горын 1994 оны 12 дугаар сард хийсэн айлчлалын үеэр Казахстаны нутаг дэвсгэр дээрх цөмийн зэвсгийг задлах тухай хэлэлцээрийг байгуулжээ. АНУ нь Узбекистантай удаашралтай өрнөж байсан харилцаагаа идэвхжүүлж, 1995 онд хоёр улсын хооронд Батлан хамгаалах яамны сувгаар хамтын ажиллагаа эхэлж, хоёр улсын харилцааг “стратегийн түншлэл” хэмээн нэрлэх болсон. Нөгөө талаар, Төв Азийн улсуудын бүрэн эрхт байдал, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг дэмжихэд анхаарч байсан нь эдгээр улсын ОХУ-аас хамаарах хамаарлыг нь бууруулах, БНХАУ-ын нөлөөнд орохоос сэргийлэх зорилготой байв.

Бүс нутаг дахь АНУ-ын эдийн засгийн сонирхол 1990-ээд оны хоёрдугаар хагаст Казахстан, Туркменистанд харьяалагддаг Каспийн тэнгисийн нефтийн нөөцтэй холбоотой үүссэн. Тус улсын нефтийн компаниуд Афганистан, Пакистанаар дамжих хоолойгоор Казахстан, Туркменистаны нефтийг экспортлох асуудлаар лоббиг 1995 оноос өрнүүлж эхэлжээ. Энэ төсөлд ерөнхийлөгч Б.Клинтоны засаг захиргааны зарим гишүүд оролцсоны дотор Ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлын туслах С.Бергер багтаж байлаа. 1992-1995 онд АНУ-аас Казахстанд 523.1 сая, Кыргызстанд 306.5 сая, Тажикистанд 152.4 сая, Туркменистанд 139.8 сая, Узбекистанд 99.5 сая ам.долларын тусламж үзүүлжээ. Энэ хүчин чармайлтын үр дүнд, Америкийн газрын тосны томоохон компаниуд

боллох Шеврон болон Эксонмобил нь Казахстанд 1993 оноос хойш үйл ажиллагаа явуулах болж, улмаар тус улсын баруун хойд хэсэгт, Каспийн тэнгисийн дагуу байрлах Казахстаны газрын тос, байгалийн хийн хамгийн том ордыг ашигладаг “Тенгизшевройл” консорциумын 50 болон 25 хувийг тус тус эзэмших боломжтой болсон. Мөн Шеврон компани нь Казахстаны хамгийн том хувийн газрын тос үйлдвэрлэгч болж, дэлхийн хамгийн том хийн конденсат ордуудын нэг болох Карачаганак ордын 18 хувийг эзэмшиж, Каспийн хоолойн консорциумын хамгийн том хувийн хувьцаа эзэмшигч болоод байгаа юм.⁵ Эксонмобил компани Кашаганы нефтийн ордыг ашиглах олон улсын консорциумын 16.81 хувийг эзэмшдэг.⁶

Ерөнхийлөгч Ж.Бушийн засаг захиргаа эхэндээ Төв Азид төдийлөн сонирхохгүй байсан боловч “9 дүгээр сарын 11”-ний дараа энэ бүс нутаг нь гео-стратегийн хувьд Афганистантай ойр гэдгээрээ Вашингтоны анхаарлыг татаж эхэлсэн. Б.Клинтоны засаг захиргаа ардчиллыг дэмжих, эдийн засгийн тусламж үзүүлэхэд анхаарч байсан бол Ж.Бушийн засаг захиргаа терроризмтэй тэмцэх зорилгоор цэрэг-батлан хамгаалах салбарын хамтын ажиллагаанд илүүтэй анхаарч, Төв Азийн улсуудын цэргийн баазуудыг ашиглан бүс нутагт цэргийн үйл ажиллагаа явуулж байлаа. Гэвч АНУ нь энэ бүс нутгийн тогтвортой байдал, аюулгүй байдлыг хангахад дорвитой хувь нэмэр оруулаагүйгээс үүдэн бүс нутагт байр сууриа бэхжүүлж чадаагүй

5 Tengizchevroil, “Overview,” at <http://www.tengizchevroil.com/en/about/overview>; Chevron, “Kazakhstan,” <https://www.chevron.com/worldwide/kazakhstan> (accessed September 5, 2022)

6 North Caspian Operating Company, “NCOC Governance and Management System,” <https://www.ncoc.kz/en/ncoc/ncoc-governance> (accessed September 5, 2022)

юм.

Ерөнхийлөгч Б.Обамагийн засаг захиргаа Афганистаны сунжирсан дайны асуудлыг шийдвэрлэх, Төв Ази дахь Орос, Хятад, Ираны нөлөөг саармагжуулах, исламын хэт даврах үзлийн сэргэлтийг хязгаарлах зэрэг өмнөх засаг захиргаанаас өвлөгдсөн асуудлуудад төвлөрч байв. Шинэ засаг захиргааны бодлогод өөрчлөлт орж, өмнө нь ардчиллын үйл явцад анхаардаг байсан бол хатуу, зөөлөн хүчийг хослуулсан “ухаалаг хүч”-ний бодлого хэрэгжүүлэх болов. Нөгөө талаар, Б.Обамагийн гадаад бодлогын гол чиглэл нь Ази, Номхон далайн бүс нутаг байснаас Төв Азийн асуудал анхаарлын гадна орхигдсон. Энэ бүс нутгийг сонирхохгүй болсон гэдэг нь Афганистанаас цэргээ гаргахаа зарласнаас харагдав.

2015 онд буюу Ерөнхийлөгч Б.Обамагийн үед АНУ болон Төв Азийн орнуудын хооронд улс төр-дипломатын хүрээнд яриа хэлэлцээ өрнүүлэх “Си5+1” механизмын эхлэл тавигдсныг энд дурдах шаардлагатай. Энэ механизм нь Вашингтон болон Төв Азийн орнуудад нийтлэг тулгамдаж буй аюулгүй байдал, эдийн засгийн хэлхээ холбоо, байгаль орчны эмзэг байдал зэрэгтэй холбоотой олон сорилт бэрхшээлийг шийдвэрлэх боломжийг олгодог. АНУ-ын Төрийн Департаментын зүгээс “энэхүү формат нь оролцогч орнуудын хооронд яриа хэлэлцээ өрнүүлэх, хамтын ажиллагаа, түншлэлийг сайжруулах, эдийн засаг, эрчим хүчний хэлхээ холбоо, худалдааг нэмэгдүүлэх, байгаль орчин,

эрүүл мэндийн сорилт бэрхшээлийг даван туулах, аюулгүй байдлын асуудлуудыг хамтран шийдвэрлэх, оролцогч орнуудын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын бүхий л салбарт эмэгтэйчүүдийг бүрэн дүүрэн оролцуулахыг дэмжих чиглэлд амжилт гаргасан”-ыг онцлон тэмдэглэсэн.⁷

Ерөнхийлөгч Д.Трампын засаг захиргааны үед өмнөх засаг захиргааны нэгэн адил Төв Азийг төдийлөн чухалчлан авч үзсэнгүй. Оросын нөлөөг хязгаарлах Америкийн бодлого үргэлжилсээр байсан боловч Хятадыг илүүтэй анхаарах шаардлага үүссэн. Үүний зэрэгцээ Д.Трампын засаг захиргаанд аюулгүй байдлын асуудал, тэр дундаа Афганистаны дайны асуудал чухалд тавигдаж байсан учраас Төв Азийн ач холбогдол нь Афганистаны дайнд “хэрэгцээтэй” гэдгээр л хязгаарлагдаж байв. Нөгөө талаар, Америкийг дахин хүчирхэг болгох зорилго тавьсан Ерөнхийлөгч Д.Трамп гадаадын зээл тусламжийг бууруулсан нь Төв Азийн улсуудын эдийн засагт хүнд туссан. АНУ нь сүүлийн 30 жилийн хугацаанд Төв Азийн орнуудын аюулгүй байдал, ардчилсан шинэчлэл, эдийн засгийн өсөлтийг дэмжих, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх зорилгоор 9 тэрбум гаруй ам.долларын шууд тусламж үзүүлээд байсан юм.⁸

Д.Трампын засаг захиргааны үеийн сүүлийн жил буюу 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Вашингтоны 2019-2025 онд хүртэл “Төв Азид чиглэсэн АНУ-ын стратеги” хэмээх баримт бичгийг боловсруулан

7 U.S. Department of State, “Joint Statement on the C5+1 Virtual Ministerial,” May 4, 2021

8 U.S. Department of State, Bureau of South and Central Asian Affairs, “United States Strategy for Central Asia 2019-2025: Advancing Sovereignty and Economic Prosperity (Overview),” February 5, 2020

гаргасан юм.⁹ Тус стратегид АНУ-аас Төв Азид хэрэгжүүлэх бодлогын үндсэн 6 чиглэлийг тодорхойлсон. Эдгээрийг дурдвал, *нэгдүгээрт*, Төв Азийн улсуудын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг тус тусад нь болон бүс нутгийн хэмжээнд дэмжин бэхжүүлэх, *хоёрдугаарт*, энэ бүс нутагт терроризмын аюулыг намжаах, *гуравдугаарт*, Афганистаны тогтвортой байдлыг хангахад үзүүлэх дэмжлэгээ өргөжүүлж хадгалах, *дөрөвдүгээрт*, Төв Ази болон Афганистаны хоорондох хэлхээ холбоог дэмжих, *тавдугаарт*, хууль эрх зүйн шинэчлэлийг дэмжих, хүний эрхийг хүндэтгэх, *зургаадугаарт*, Төв Ази дахь АНУ-ын хөрөнгө оруулалт болон бүс нутгийн хөгжлийг дэмжих зэрэг юм. Товчоор хэлбэл, энэхүү баримт бичиг нь Төв Ази дахь АНУ-ын стратегийн ашиг сонирхлыг

бататган тодорхойлж, хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, хүрээг гаргаж өгснөөрөө ач холбогдолтой юм.

Төв Азид сүүлийн 30 жилийн хугацаанд АНУ-ын засаг захиргааны хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд АНУ-ын хувийн хэвшлийнхэн тус бүс нутагт 31 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө оруулалт хийгээд байгаа юм. Мөн Төв Азийн орнууд болон АНУ-ын иргэд хоорондын харилцаа холбоог дэмжих зорилгоор Вашингтоны шууд санхүүжилттэйгээр 40 мянган гаруй хүнийг оюутан, мэргэжлийн солилцооны хөтөлбөрүүдэд хамруулаад байна. Хэдийгээр энэ мэт амжилтууд харагдаж байгаа боловч Төв Ази нь Вашингтоны гадаад бодлогод хоёрдагч бүс нутгийн хэмжээнд тавигдсаар ирсэн нөхцөл байдал өөрчлөгдөлгүй, Ж.Байдены засаг захиргаатай золгосон юм.

Гурав. Ерөнхийлөгч Ж.Байдены Төв Азийн бодлого ба Афганистанаас АНУ-ын цэргийг гаргасан нь

Ерөнхийлөгч Ж.Байден албан ажилдаа ороод исламын хэт даврагч, террорист бүлэглэлүүдтэй өрнүүлсэн 20 жилийн дайныг дуусган АНУ-ын цэргийг Афганистанаас гаргаснаар Америкийн түүхэн дэх хамгийн урт дайныг төгсгөл болгосон билээ. АНУ-ын сүүлийн гурван ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацааг дамнан үргэлжилсэн цэрэг гаргах үргэлжилсэн үйл явц нь 2400 гаруй цэргийн амь насыг авч одож, 2 их наяд ам.долларыг шаардсан юм. Афганистанаас

Америкийн цэргийг бэлтгэлгүйгээр гэнэт гаргах болсон Ж.Байдены ийнхүү шийдвэрийг түүний гадаад бодлогын эхний том алдаа хэмээн судлаачид дүгнэдэг. Үүнээс үүдэн Ж.Байдены нэр хүнд дотооддоо унаад зогсохгүй дэлхий даяарх АНУ-ын манлайлалд улс гүрнүүд эргэлзэхэд хүрээд байна. Учир нь Америкийн цэрэг гарснаар талибан, Аль-Кайда болон Исламын улс бүлэглэлүүдийн үйл ажиллагаа Афганистанд эрчимжиж, улмаар 8 дугаар сарын 15-ны өдөр Кабулыг

9 U.S. Department of State “United States Strategy for Central Asia 2019-2025: Advancing Sovereignty and Economic Prosperity (Overview)” <https://www.state.gov/united-states-strategy-for-central-asia-2019-2025-advancing-sovereignty-and-economic-prosperity/#:~:text=The%20United%20States%20primary%20strategic,international%20investment%3B%20and%20has%20strong%2C> (accessed September 9, 2022)

эээлснээсээ хойш сар хүрэхгүй хугацааны дараа буюу 9 дүгээр сарын 10-нд Афганистаныг бүрэн хяналтандаа авснаа талибууд зарласан. Өөрөөр хэлбэл, АНУ-ын 20 жилийн дайн ямар ч үр дүнд хүрээгүй гэсэн мессежийг өгч байгаа юм. Үүнтэй холбогдуулан, Чехийн ерөнхийлөгч Милош Земан “Афганистанаас цэргээ гаргаснаар АНУ дэлхийн лидер гэх нэр хүндээ алдлаа”¹⁰ хэмээн мэдэгдснээс үзэхэд энэ нь улс орнууд Вашингтоны олон улсын харилцаан дахь манлайлалд эргэлзэхэд хүргэсэн гэж хэлж болно.

АНУ-ын Ерөнхийлөгч Ж.Байден гаргасан шийдвэрээ зөвтгөж, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганд оролцож үг хэлэхдээ, АНУ-ын дипломат ажиллагааны “шинэ эрин” эхэлж буйг зарлан тунхаглаж, Афганистаны асуудлаас хөндийрч чадснаар Вашингтон уур амьсгалын өөрчлөлт, цар тахал, терроризм зэрэг дэлхий нийтийн шинжтэй асуудалд анхаарал тавих боломжтой болсныг цохон тэмдэглэсэн билээ.¹¹ Мөн тэрээр Афганистанаас Америкийн цэргийг гаргах болсон шалтгааныг “манай стратегийн жинхэнэ өрсөлдөгчид болох Хятад, Орос Афганистаныг

тогтворжуулахад олон тэрбум ам.долларын нөөцөө зарж, анхаарал төвлөрүүлсэн байхыг л АНУ-аас хүсч байгаа” хэмээн тайлбарласан билээ.¹²

Афганистанаас Америкийн цэрэг гарснаас үүдэн Төв Азид Оросын аюулгүй байдлын оролцоо нэмэгдэнэ хэмээн зарим шинжээчид үзэж байна.¹³ Афганистанд талибууд хяналтаа тогтоосноор энэ бүс нутаг болон Азийн хэмжээнд Хятадын нөлөө нэмэгдэж болзошгүй хэмээн үзэх судлаачид байна.¹⁴ Үүнээс эсрэгээр, “АНУ нь Төв Азид Орос, Хятадын нөлөөг тэнцвэржүүлэгч үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэсээр байх тул тус бүс нутгийн орнуудын их гүрнүүдтэй харилцах харилцаа нь бараг өөрчлөгдөхгүй байх магадлалтай” хэмээн дүгнэх нь ч байна.¹⁵ Талибан хөдөлгөөнийг Афганистаны засгийн эрхийг авсан явдал Узбекистаны илүү идэвхтэй бодлого явуулахад хүргэж магадгүй юм. Тодруулбал, Төв Азийн хамгийн олон хүн амтай улс болохын хувьд Узбекистан бүс нутагтаа тэргүүлэгч болох амбицаа хэрэгжүүлэхэд илүү их хүчин чармайлт тавьж, бүс нутгийн хамтын ажиллагааг бий болгоход идэвхтэй ажиллахыг эрмэлзэх

10 Tass “US lost prestige of global leader after withdrawing from Afghanistan — Czech president” <https://tass.com/world/1327131>

11 Politico “Biden declares ‘new era’ of U.S. diplomacy in U.N. speech” <https://www.politico.com/news/2021/09/21/biden-diplomacy-united-nations-speech-513384> (accessed September 9, 2022)

12 The White House “Remarks by President Biden on Afghanistan” <https://www.whitehouse.gov/briefing-room/speeches-remarks/2021/08/16/remarks-by-president-biden-on-afghanistan/> (accessed September 9, 2022)

13 TemurUmarov, “Do the Taliban Pose a Threat to Stability in Central Asia?” Carnegie Moscow Center, September 3, 2021; Kate Mallinson, “Afghanistan Creates Tricky New Reality for Central Asia,” Chatham House, August 27, 2021; Andrew Kramer and Anton Troianovski, “With Afghan Collapse, Moscow Takes Charge in Central Asia,” New York Times, August 19, 2021.

14 KhursandKhurramov, “Usilitsia li vliianieKitaia v regione posle prikhoda k vlasti ‘Taliban?’” [Will the influence of China in the region increase after the Taliban have come to power?] Radio Ozodi, September 16, 2021; Reid Standish, “China Cautiously Eyes New Regional Leadership Role As Afghanistan Fighting Intensifies,” RFE/RL, July 14, 2021.

15 Bruce Pannier, “How Much Will Afghanistan Change Central Asia’s Relations with Russia, China, and the United States?” RFE/RL, August 24, 2021.

магадлалтай.

Ямартаа ч Америкийн цэргийг Афганистанаас гаргасантай холбоотойгоор бүс нутгийн аюулгүй байдлын орчинд өөрчлөлт орсонд нийцүүлэн Ж.Байдены засаг захиргаа Төв Азид чиглэсэн АНУ-ын бодлого нэмэлт, өөрчлөлт хийгээгүй байгаа нь анхаарал татаж байна. Үүний оронд өнөөгийн засаг захиргаа Б.Обама, Д.Трампын үеэс АНУ-ын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болсон Ази, Номхон далайн бүс нутагт анхаарсан бодлогыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Д.Трампын үеэс “Энэтхэг-Номхон далай” хэмээх нэрших болсон энэхүү бүс нутагт хэрэгжүүлэх стратегиа тусгайлан тодорхойлсон бодлогын баримт бичгийг 2022 оны 2 дугаар сарын 12-ны өдөр танилцуулсан.¹⁶ Тус баримт бичгийн агуулгад дүн шинжилгээ хийхэд Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлах нь АНУ-ын “grand strategy”-ийн хамгийн чухал зорилт болох нь харагдаж байна. Харин Төв Азид ямар бодлого баримтлах замаар БНХАУ-ын энэ бүс нутгаас гарааг нь эхлүүлсэн (БНХАУ-ын дарга Си Зиньпин 2013 онд Казахстанд анх зарласан) “Бүс ба зам” санаачилгыг хэрхэн хязгаарлах, улмаар тус бүс нутгаас Бээжинг шахан гаргах нь тодорхойгүй байгаа юм.

Транс-Атлантын аюулгүй байдлын орчинд “сүйрлийн” шинжтэй

өөрчлөлтийг авчирсан ОХУ-ын Украинд явуулж буй цэрэг-дайны үйл ажиллагаа нь АНУ-ыг Европын хэрэг явдалд анхаарахгүй байхаас өөр аргагүй байдалд оруулаад байна. Өөрөөр хэлбэл, Европын хэрэг явдлаас үүдэн Төв Ази нь дахин Вашингтоны анхаарлын гадна үлдэх магадлалтай байна. Нөгөөтэйгүүр, Төв Азийн орнууд Украинд Оросын явуулж буй “цэргийн тусгай үйл ажиллагаа”-ны талаар төвийг сахьсан байр суурь баримталж байна.¹⁷ Эдгээр улс Оросын үйл ажиллагааг зэмлэн буруушаах эсвэл дэмжсэн байр суурийг илэрхийлээгүй юм.¹⁸ НҮБ-ын Ерөнхий Ассамблейд Украинд ОХУ-ын явуулж буй үйл ажиллагааг зэмлэн буруушаасан тогтоолоор санал хураахад Төв Азийн орнууд санал хураалтад оролцоогүй буюу санал өгөхөөс татгалзсан.¹⁹ Гэхдээ 2022 оны 4-р сарын 8-нд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас ОХУ-ыг Хүний эрхийн зөвлөлөөс гаргах шийдвэр гаргахад Туркменистанаас бусад Төв Азийн 4 улс ОХУ-ыг дэмжсэн байна.²⁰

Төв Ази Оросын ашиг сонирхлын амин чухал бүс нутаг гэдгийг эртнээс гадарлах АНУ энэ бүс нутаг дахь оролцоогоо огцом хумих бодлого баримтлахгүй болов уу. Европт үүссэн дайн-байлдааны нөхцөл намжихтай зэрэгцэн Төв Азид Орос, Хятадын нөлөөг саармагжуулах бодлогыг

16 The White House “Indo-Pacific Strategy” (February 2022) <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2022/02/U.S.-Indo-Pacific-Strategy.pdf> (accessed September 9, 2022)

17 Johan Engvall, “Russia's War in Ukraine: Implications for Central Asia”, The Central Asia-Caucasus Analyst, 14 March 2022

18 Catherine Putz, “Central Asia Sides with Russia in UN Human Rights Council Vote”, The Diplomat, 8 April 2022

19 Catherine Putz, “Central Asia Sides with Russia in UN Human Rights Council Vote”, The Diplomat, 8 April 2022

20 Asia-Plus Team, “Kazakh Leader Offers to Mediate between Russia and Ukraine if need be”, Asia-Plus, 1 March 2022

идэвхтэй явуулах магадлалтай. Төв Азид Ж.Байдены засаг захиргаа бодлогоо хэрэгжүүлэхдээ үнэт зүйл нэгтэй Энэтхэгийн нөлөөнд тулгуурлах боломжтой хэмээн судлаачдын зарим нь үзэж байна. ШХАБ-ын томоохон гишүүдийн нэг болох Энэтхэг нь АНУ-ын Төв Азид чиглэсэн олон талт дипломат бодлогод чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.²¹ Бүс нутгаасаа хальж ашиг сонирхлоо тодорхойлох, бусад бүс нутагт идэвхтэй үүрэг гүйцэтгэх, Евразийн бүс нутагт Хятадын өсөн нэмэгдэж буй нөлөөг хязгаарлах боломжтой болно гэх стратегийн тооцооны улмаас Энэтхэг ШХАБ-д нэгдсэн.²² Төв Азийн бүс нутагт идэвхтэй бодлого явуулахыг эрмэлздэг Энэтхэгийн бодлогод тулгуурлан АНУ-ын Төв Азийн орнуудтай хамтрах боломж харагдаж байна. Гэхдээ шашны үнэт зүйлийн хувьд Төв Азийн орнуудтай нийтлэг бүс Энэтхэг нь Төв Ази дахь АНУ-ын бодлогыг урагшлуулахад томоохон нөлөө үзүүлнэ гэдэг нь эргэлзээтэй юм.

АНУ нь Энэтхэгийн оронд НАТО-гийн гишүүн Туркээр дамжуулан Төв Азид нөлөөлөх нь илүү үр дүнтэй байж болох юм. Хэдийгээр Турк нь шашин, үндэстэн, хэлний хувьд Төв Азийн орнуудтай нийтлэг зүйл олон боловч АНУ-ын бодлогыг энэ бүс нутагт хэрэгжүүлэгч болохыг

сонирхохгүй юм. Учир нь Турк өөрөө энэ бүс нутагт хүчтэй нөлөө үзүүлэх, түүнчлэн Европын Холбоонд нэгдэж чадахгүй тохиолдолд ШХАБ-аар орлуулсан интеграцын бодлого хэрэгжүүлнэ. Тийм учраас Турк 2012 онд ШХАБ-ын яриа хэлэлцээний түнш болсноосоо хойш тус байгууллагад элсэх боломжтой гэдгээ удаа дараа илэрхийлж ирсэн.²³ Мөн 1990-ээд онд АНУ нь Туркээр дамжуулан Төв Азид оролцоотой болохыг оролдсон нь амжилтанд хүрээгүй билээ.²⁴

Тэгэхээр АНУ-ын Төв Азийн орнуудтай шууд түншлэн харилцахаас өөр сонголт үлдсэнгүй. Ингэхдээ Казахстан, Узбекистан зэрэг бүс нутгийн нөлөө бүхий орнуудтай түншлэнэ хэмээн Америкийн судлаачид үзэж байна.²⁵ Төв Азийн бүс нутгийн хамгийн том газар нутагтай, эдийн засаг, цэргийн хүчирхэг тоглогч, тус бүс нутагт орж буй ГШХО-ын 75 хувийг өөртөө шингээдэг²⁶ Казахстантай түншлэх нь АНУ-ын ашиг сонирхолд нийцнэ. Нөгөөтэйгүүр, Казахстаны 1990-ээд оноос хэрэгжүүлж буй “олон чиглэлт” (multi-vector) гадаад бодлого нь ОХУ, БНХАУ, АНУ, Европын Холбоотой харилцаандаа стратегийн тэнцвэрийг хангахыг чиглэдэг учраас энэ нь АНУ-тай Төв Азид хамтран ажиллах үндэс болж болох юм. Узбекистаны

21 AYJAZ WANI “Beyond “Grievance States”—Biden on Central Asia” <https://www.orfonline.org/expert-speak/beyond-grievance-states-biden-on-central-asia/> (accessed September 9, 2022)

22 Mann Poonam. (2016). India's Membership in the SCO: Opportunities and Challenges. *Journal of Air Power and Space Studies*, 11(2), 125-44.

23 Ministry of Foreign Affairs, Turkey “Shanghai Cooperation Organization” <https://www.mfa.gov.tr/shanghai-cooperation-organization.en.mfa> (accessed September 10, 2022)

24 Olcott, M. *Central Asia's New States: Independence, Foreign Policy, and Regional Security*.

25 Barak M. Seener “After Afghanistan, Biden Needs to Re-Engage Central Asia” <https://nationalinterest.org/feature/after-afghanistan-biden-needs-re-engage-central-asia-194238> (accessed September 5, 2022)

26 Foreign Policy “Kazakhstan aims to become a destination for global investment” <https://foreignpolicy.com/sponsored/kazakhstan-aims-to-become-a-destination-for-global-investment/> (accessed September 5, 2022)

тухайд, АНУ нь тус улсыг олон жил удирдсан Ерөнхийлөгч И.Каримовын үеэс эхлэн идэвхтэй харилцаж ирсэн уламжлалтай. Үүн дээр дөрөөлөн Узбекистантай харилцаагаа гүнзгийрүүлэх, ингэхдээ тус улсын “сайн хөрш”-ийн бодлогод тулгуурлах замаар бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх гэсэн амбицыг нь ашиглах

боломжтой.²⁷ Өөрөөр хэлбэл, хэдийгээр Афганистанаас цэргээ гаргаснаар Төв Азид АНУ-ын оролцоо буурах боловч тус бүс нутгийн хүчирхэг эдийн засагтай, хүн ам олонтой улсуудаар дамжуулан бүс нутагт оролцоогоо хадгалах бодлогыг Ерөнхийлөгч Ж.Байдены засаг захиргаа явуулна хэмээн үзэж байна.

Дүгнэлт

Төв Ази бол дэлхийн геополитикт чухал нөлөөтэй бүс нутаг юм. Тиймээс зөвхөн АНУ гэлтгүй ОХУ, БНХАУ зэрэг их гүрнүүдийн сонирхлыг татсаар ирсэн. 2001 оноос өмнө “далайн их гүрэн” АНУ тус бүс нутагт нэвтрэх боломжгүй байсан бол 9/11-ий үйл явдал үүнийг нөхцөлдүүлж өгсөн юм. Афганистанд явуулсан байлдааны үйл ажиллагааны үр дүнд, АНУ-ын 2001 оноос хойш Төв Азид хэрэгжүүлсэн бодлого нь аюулгүй байдлын хамтын ажиллагаа өрнүүлэх, түүний дотор Афганистаныг тогтворжуулахад голлон анхаарч байв. АНУ нь Төв Азийн бүх улстай аюулгүй байдлын чиглэлээр хамтран ажиллаж, сургалт явуулах, энхийг сахиулах болон гамшгийн үед хариу арга хэмжээ авах чадавхийг сайжруулах, хилийн аюулгүй байдлыг бэхжүүлэх хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байв. Төв Азид бусад хэлбэрээр оролцох боломж

хязгаарлагдмал байсан нөхцөлд аюулгүй байдлын хамтын ажиллагаа нь АНУ болон бүс нутгийн орнуудын хооронд хоёр талын харилцаа, хамтын ажиллагааг хадгалах боломжийг олгосон.

Афганистанд Америкийн цэргийн ажиллагааг бүрмөсөн дууссантай холбоотойгоор Д.Трампын засаг захиргааны 2020 онд боловсруулсан Төв Азийн талаар баримтлах стратегид өөрчлөлт, тохируулга хийгээгүй байгаагаас үзэхэд АНУ-ын өнөөгийн засаг захиргааны гадаад бодлогод Төв Ази төдийлөн ач холбогдолтой бус байгаа нь харагдаж байна. Гэвч дэлхийн бодлогын “зүрхэн газар” болох Төв Азид нөлөөтэй байх, тус бүс нутагт Орос, Хятадын нөлөөг хязгаарлах нь АНУ-ын “хар хайрцаг”-ны бодлогын чухал хэсэг байсаар байх болов уу хэмээн судлаачийн зүгээс дүгнэж байна.

27 Catherine Putz “A New US Strategy for Central Asia: Continuity Under Better Conditions” <https://thediplomat.com/2020/02/a-new-us-strategy-for-central-asia-continuity-under-better-conditions/> (accessed September 10, 2022)

Ном зүй:

1. Alam M. M. US Policy In Central Asia: Problems And Prospects
2. Asia-Plus Team, “Kazakh Leader Offers to Mediate between Russia and Ukraine if need be”, Asia-Plus, 1 March 2022
3. Ayjaz Wani “Beyond “Grievance States”—Biden on Central Asia” <https://www.orfonline.org/expert-speak/beyond-grievance-states-biden-on-central-asia/>
4. Barak M. Seener “After Afghanistan, Biden Needs to Re-Engage Central Asia” <https://nationalinterest.org/feature/after-afghanistan-biden-needs-re-engage-central-asia-194238>
5. Bruce Pannier, “How Much Will Afghanistan Change Central Asia’s Relations with Russia, China, and the United States?” RFE/RL, August 24, 2021.
6. Catherine Putz “A New US Strategy for Central Asia: Continuity Under Better Conditions” <https://thediplomat.com/2020/02/a-new-us-strategy-for-central-asia-continuity-under-better-conditions/>
7. Foreign Policy “Kazakhstan aims to become a destination for global investment” <https://foreignpolicy.com/sponsored/kazakhstan-aims-to-become-a-destination-for-global-investment/>
8. Johan Engvall, “Russia’s War in Ukraine: Implications for Central Asia”, *The Central Asia-Caucasus Analyst*, 14 March 2022
9. KhursandKhurramov, “Usilitsia li vliianieKitaia v regione posleprikhoda k vlasti ‘Taliban’?” [Will the influence of China in the region increase after the Taliban have come to power?] Radio Ozodi, September 16, 2021; Reid Standish, “China Cautiously Eyes New Regional Leadership Role As Afghanistan Fighting Intensifies,” RFE/RL, July 14, 2021
10. Mann Poonam. (2016). India’s Membership in the SCO: Opportunities and Challenges. *Journal of Air Power and Space Studies*, 11(2), 125-44.
11. Ministry of Foreign Affairs, Turkey “Shanghai Cooperation Organization” <https://www.mfa.gov.tr/shanghai-cooperation-organization.en.mfa>
12. North Caspian Operating Company, “NCOC Governance and Management System,” <https://www.ncoc.kz/en/ncoc/ncoc-governance>
13. Olcott, M. Central Asia’s New States: Independence, Foreign Policy, and Regional Security.
14. Politico “Biden declares ‘new era’ of U.S. diplomacy in U.N. speech” <https://www.politico.com/news/2021/09/21/biden-diplomacy-united-nations-speech-513384>
15. RozaNurgozhayeva, the Diplomat “How Is China’s Belt and Road Changing Central Asia?” (July 9, 2020) <https://thediplomat.com/2020/07/how-is-chinas-belt-and-road-changing-central-asia/>
16. TASS “Decision taken on denazification, demilitarization of Ukraine — Putin” (February 24, 2022) https://tass.com/politics/1409189?utm_source=google.com&utm_medium=organic&utm_campaign=google.com&utm_referrer=google.com

17. Temur Umarov, “Do the Taliban Pose a Threat to Stability in Central Asia?” Carnegie Moscow Center, September 3, 2021; Kate Mallinson, “Afghanistan Creates Tricky New Reality for Central Asia,” Chatham House, August 27, 2021; Andrew Kramer and Anton Troianovski, “ With Afghan Collapse, Moscow Takes Charge in Central Asia,” New York Times, August 19, 2021
18. Tengizchevroil, “Overview,” at <http://www.tengizchevroil.com/en/about/overview/>; Chevron, “Kazakhstan,” <https://www.chevron.com/worldwide/kazakhstan>
19. The White House “Remarks by President Biden on Afghanistan” <https://www.whitehouse.gov/briefing-room/speeches-remarks/2021/08/16/remarks-by-president-biden-on-afghanistan/>
20. The White House “Indo-Pacific Strategy” (February 2022) <https://www.whitehouse.gov/wp-content/uploads/2022/02/U.S.-Indo-Pacific-Strategy.pdf>
21. Troitskiy, E, F. US policy in central Asia and regional security
22. Tom Blanton and Svetlana Savranskaya, eds., “Kazakhstan and Nunn-Lugar: A Non-Proliferation Success Story,” National Security Archive, National Security Archive Electronic Briefing Book, No. 528, Washington, DC, 2015
23. U.S. Department of State, “Joint Statement on the C5+1 Virtual Ministerial,” May 4, 202
24. U.S. Department of State, Bureau of South and Central Asian Affairs, “ United States Strategy for Central Asia 2019-2025: Advancing Sovereignty and Economic Prosperity (Overview),” February 5, 2020
25. U.S. Department of State “United States Strategy for Central Asia 2019-2025: Advancing Sovereignty and Economic Prosperity (Overview)” <https://www.state.gov/united-states-strategy-for-central-asia-2019-2025-advancing-sovereignty-and-economic-prosperity/#:~:text=The%20United%20States'%20primary%20strategic,international%20investment%3B%20and%20has%20strong%2C>
26. Warsaw Institute “The strategic partnership between China and Russia at the time of the pandemic” (July 14, 2020) <https://warsawinstitute.org/strategic-partnership-china-russia-time-pandemic/>

The U.S. policy towards Central Asia

Byambakhand Luguusharav

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
byambakhand_l@mas.ac.mn*

Abstract: *After the 9/11 terrorist attacks, the United States launched military operations and deployed its troops in Afghanistan. In August 2021, the United States withdrew the last of its troops from Afghanistan, ending its military presence there after nearly 20 years, a result of the “Agreement for Bringing Peace for Afghanistan” signed with the Taliban. According to expectations by the experts whose eyes are on Central Asia, the withdrawal of U.S. troops from Afghanistan would bring some changes to the U.S. policy towards the region which is close to Afghanistan. However, the U.S. has to focus on the European theatre, as Russia launched a “special operation” in Ukraine by justifying its action as a “crusade” against neo-Nazis. Russia’s military actions have forced Washington to shift its attention to transatlantic security, leaving a vacuum in Central Asia to be filled by Russia and China.*

In the first part of the article, the author seeks to analyze the geopolitical importance of Central Asia and the competition of great powers to expand their influence in the region. As stated in the Constitution of the United States, as the Chief Executive, the president has the authority in shaping the foreign policy of the country, so the second part of the article is for the discussion of the U.S. presidents’ policies toward Central Asia. At the end of the article, as a researcher, the author seeks to share her take on the possible changes in Washington’s policy in Central Asia with respect to President Joe Biden’s decision to withdraw U.S troops from Afghanistan.

Keywords: *Central Asia, US policy, Afghanistan, geopolitics, interests*

The day of submission: 2022.09.09

Completion of review: 2022.11.01

Final decision for acceptance: 2022.11.08